

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН
2013 ОНЫ ГУРАВДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2013.10.29


Улаанбаатар хот

НЭГ. ББСБ-ЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2013 оны гуравдугаар улирлын байдлаар Хорооны хуралдаанаар 59 ББСБ-ын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 35 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгож, 2 ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор тайлант хугацааны эцэст нийт 245 ББСБ Хорооноос олгосон тусгай зөвшөөрлөөр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байна.

Тусгай өвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ -уудын тооньөөрчлөлтийг графикаар үзүүлбэл:

/График 1/



Тайлант хугацаанд Хорооны хуралдаанаар тусгай зөвшөөрөлтэй ББСБ -уудын асуудлуудыг хэрхэн шийдвэрлэсэн байдлыг өмнөх оны эцсийн үзүүлэлттэй харьцуулбал:

/Хүснэгт 1/

№	Тайлант хугацаа	Тайлант хугацаа		
		2012 оны жилийн эцэст	2013 оны гуравдугаар улирлын байдлаар	өөрчлөлт
1	Тусгай зөвшөөрлийг сунгасан	40	59	+19
2	Тусгай зөвшөөрөл шинээр олгосон	23	35	+12
3	Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон	6	2	-4
4	Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн	4	2	-2
5	Тусгай зөвшөөрлийг сэргээсэн	2	-	-2
6	Тайлант хугацааны эцэс дэх ББСБ-ын тоо	212	245	+33

ББСБ-уудын нийт тоо болон орон нутаг үйл ажиллагаа явуулж буй ББСБ -ын тооны өөрчлөлтийг харуулбал:

/Хүснэгт 2/

№	Тайлант хугацаа	Тайлант	Үүнээс:
---	-----------------	---------	---------

		хугацааны эцэс дэх ББСБ-ын тоо	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ	Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ	Зөвхөн гадаад валютын арилжаа эрхэлж буй ББСБ
1	2008 он	132	23	11	-
2	2009 он	177	27	9	47
3	2010 он	182	26	15	48
4	2011 он	195	23	17	39
5	2012 он	212	24	18	38
6	2013.I улирал	229	25	18	39
7	2013.II улирал	233	25	18	39
8	2013.III улирал	245	27	18	39

2013 оны гуравдугаар улирлын байдлаар сөн дүнгээр/ Баянхонгор аймагт 3, Баян - Өлгий аймагт 1 ББСБ тус бүр 50.0 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр, Улаанбаатар хотод 32 ББСБ 200.0-672.0 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр зээл, гадаад валютын арилжаа, өрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байна.

2013 оны гуравдугаар улирлын байдлаар Хорооны хуралдаанаар банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай өвшөөрлийг сэргээсэн тохиолдол байхгүй, 2 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, 2 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.

ББСБ-уудыг Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан үйл ажиллагаа, үйлчилгээ эрхэлж буйгаар нь ангилвал:

/Хүснэгт 5/

№	Үйл ажиллагааны нэр төрөл	Үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын тоо	
		2012 оны гуравдугаар улирлын байдлаар	2013 оны гуравдугаар улирлын байдлаар
1	Зээл	164	203
2	Факторингийн үйлчилгээ	12	13
3	Төлбөрийн баталгаа гаргах	8	9
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	-	-
5	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	5	5
6	Гадаад валютын арилжаа: Нийт	92	99
	Үүнээс: Гадаад валютын арилжааг дагнан эрхэлдэг	38	39
7	Итгэлцлийн үйлчилгээ	18	20
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	2	2
9	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	16	20
10	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	-	-
11	Хөрөнгө оруулалтын үйлчилгээ ¹ /Венчур хөрөнгө оруулалт/	1	-

2013 оны гуравдугаар улирлын байдлаар банк бус санхүүгийн тусгай зөвшөөрөлтэй 245 ББСБ-ын 82.9 хувь нь зээл, 40.4 хувь нь гадаад валютын арилжаа /15.9 хувь нь гадаад валютын арилжааг дагнан эрхэлдэг/, 8.2 хувь өрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, 2.0 хувь нь цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, 5.3 хувь нь факторингийн үйлчилгээ, 3.7 хувь нь төлбөрийн баталгаа гаргах, 7.7 хувь нь итгэлцлийн үйлчилгээ, 0.8 хувь нь богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээг тус тус эрхлэн явуулж байна.

¹Банк бус санхүүгийн үйл ажиллагааны хуульд заагдсан тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд хамаарахгүй бөгөөд Хорооны 2008 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 185 дугаар тогтоолоор батлагдсан "Банк бус санхүүгийн байгууллагаас хөрөнгө оруулалтын үйлчилгээ үзүүлэх түр журам"-ыг баталсан.

Тайлант хугацаанд 6 ББСБ тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны төрлийг шинээр авсан бөгөөд 2 ББСБ үйл ажиллагааны тодорхой нэр төрлөө хүчингүй болгосон байна.

2013 оны гуравдугаар улирлын байдлаар тайлангийн ирц 99.2 хувь буюу ирүүлбэл зохих 245 ББСБ-аас 243 ББСБ тайлангаа ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, итгэлцэл, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхэлдэг болон тайлангийн хариу явуулах шаардлагатай гэж үзсэн 36 ББСБ-д тайлангийн хариуг хүргүүлээд байна.

ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ

2.1. Ерөнхий статистик үзүүлэлтүүд:

Өмнөх оны жилийн эцсийн голлох статистик үзүүлэлтүүдийг 2013 оны гуравдугаар улирлын тайлант хугацааны байдалтай харуулбал: Үүнд

№	Үндсэн үзүүлэлтүүд	2012 оны жилийн эцэст	2013 оны гуравдугаар улиралд	Өсөлт +/-, бууралт -/-
1	ББСБ-ын тоо	212	245	33
2	Хувьцаа эзэмшигчдийн тоо	599	638	39
3	Ажиллагсадын тоо	1,193	1,343	150
4	Салбар нэгжийн тоо	69	76	7
5	Харилцагчдын тоо	483,015	533,016	50,001.00
6	Нийт актив /мянган төгрөгөөр/	252,053,541.4	344,064,023.00	92,010,481.60
Банкны салбарт эзлэх хувь		2.10%	1.89%	-0.21%
7	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	157,769,345.8	209,591,331.5	51,821,985.70
Банкны салбарт эзлэх хувь		2.24%	2.04%	-0.2%
8	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	171,296,659.6	216,371,696.6	45,075,037.00
Банкны салбарт эзлэх хувь		17.38%	17.87%	0.49%
9	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	139,194,226.2	172,025,247.3	32,831,021.10
Банкны салбарт эзлэх хувь		44.94%	46.88%	1.94%
10	Итгэлцлийн үйлчилгээний өглөг /мянган төгрөгөөр/	14,111,454.9	18,366,924.1	4,255,469.20
11	Банк, банк бус санхүүгийн байгууллагаас татсан зээл /мянган төгрөгөөр/	46,142,177.6	76,367,818.8	30,225,641.20
	Үүнээс: Богино хугацаат зээл/мянган төгрөгөөр/	25,469,545.7	51,129,333.5	25,659,787.80
	Урт хугацаат зээл /мянган төгрөгөөр/	20,672,631.9	25,238,485.3	4,565,853.40
12	Төслийн зээлийн санхүүжилт /мянган төгрөгөөр/	7,977,378.4	11,128,560.7	3,151,182.30
13	Нийт орлого /мянган төгрөгөөр/	116,157,189.5	72,051,924.00	(44,105,265.50)
14	Нийт зардал /мянган төгрөгөөр/	51,903,731.8	51,006,795.00	(896,936.80)
15	Тайлант үеийн ашиг /мянган төгрөгөөр/	18,579,379.1	21,014,753.6	2,435,374.50

2013 оны гуравдугаар улирлын байдлаар ББСБ-ын нийт актив оны эхнээс 36.5 хувиар өссөн бөгөөд энэхүү өсөлтөд хувь нийлүүлсэн хөрөнгө 32.8 тэрбум төгрөгөөр тухайлвал тайлант хугацаанд шинээр тусгай зөвшөөрөл авсан 35 ББСБ -ын нийт хувь нийлүүлсэн хөрөнгө 12.9 тэрбум төгрөг, тайлант хугацаанаас өмнө тусгай зөвшөөрөлтэй байсан ББСБ-ууд нийт 21.8 тэрбум өгрөгөөр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүндээ өөрчлөлт оруулсан буюу нэмэлт хөрөнгө оруулалт, хуримтлагдсан ашгаар нэмэгдүүлсэн нь нөлөөлсөн.

Тайлант хугацаанд нийт 9 салбар шинээр байгуулагдаж, 2 салбар хүчингүй болж, 35 ББСБ шинээр үүсгэн байгуулагдаж, 2 ББСБ-ын тусгай зөвшөөрөл хүчингүй болсон бөгөөд ББСБ -д ажиллах боловсон хүчний тоо 1,343, харилцагчдын тоо 533,016 байна.

2013 оны гуравдугаар улирлын байдлаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн дагуу тусгай өвшөөрөлтэй 245 ББСБ байгаагийн 89.0 хувь буюу 218 ББСБ нь УБ хотод, 11.0 хувь буюу 27 ББСБ нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

ББСБ-уудын байршлыг графикаар үзүүлбэл:

/график 2/



2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ:

2013 оны гуравдугаар улирлын байдлаар орон нутагт 27 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 11.0 хувийг, тэдгээрийн актив нь нийт ББСБ-ын активын 2.6 хувийг, олгосон зээл, түүнтэй адилтган тооцох актив нь нийт ББСБ-ын зээлийн үлдэгдлийн 2.7 хувийг, эзэмшигчдийн өмч нь нийт ББСБ -ын эзэмшигчдийн өмчийн 3.0 хувийг, хувь нийлүүлсэн хөрөнгө нь нийт ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн 2.6 хувийг тус тус эзэлж байна. Үүнд:

/Хүснэгт 9/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2012 оны жилийн эцэс	2013 оны гуравдугаар улиралд	Өсөлт /+/, бууралт /-/
	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	24	27	+3
	ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь	12.12%	11.02%	-2.10%
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	6,254,321.4	7,041,230.0	786,908.60
	ББСБ-ын нийт активт эзлэх хувь	2.48%	2.69%	0.43%
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	4,802,425.5	5,638,796.8	836,371.3
	ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	3.04%	2.69%	-0.35%
	Чанаргүй зээл /мянган төгрөгөөр/	111,512.1	145,897.1	34,385.0
В	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	5,655,029.6	6,450,845.1	795,815.5
	ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь	3.30%	2.98%	-0.32%
Г	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	4,434,871.2	4,549,610.4	114,739.2
	ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь	3.19%	2.64%	-0.55%
Д	Банк, банк бус санхүүгийн байгууллагаас татсан зээл /мянган төгрөгөөр/	164,555.6	156,094.0	-8,461.6
	Үүнээс: Богино хугацаат зээл /мянган төгрөгөөр/	-	100,000.0	
	Урт хугацаат зээл /мянган төгрөгөөр/	164,555.6	56,094.0	-108,461.6

Е	Төслийн зээлийн санхүүжилт /мянган төгрөгөөр/	134,999.7	89,999.7	-45,000.0
Ё	Нийт орлого /мянган төгрөгөөр/	1,429,326.0	1,322,174.24	-107,151.76
Ж	Нийт зардал /мянган төгрөгөөр/	665,603.05	609,421.63	-56,181.42
З	Тайлант үеийн ашиг /мянган төгрөгөөр/	763,722.9	709,912.9	-53.810.0

Хорооноос орон нутагт үйл ажиллагаа явуулж буй бичил санхүүгийн байгууллагуудын тоог нэмэгдүүлэх, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх ажлын хүрээнд орон нутагт үйл ажиллагаа явуулах ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг ялгавартай тогтоосон хэдий ч дорвитой өсөлт гарахгүй байгаа нь орон нутагт бичил санхүүгийн үйлчилгээний ач тусын талаар ойлголт муу, санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээлэл, сурталчилгаа байхгүй байгаатай холбоотой байна.

2.3 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ:

2013 оны гуравдугаар улирлын байдлаар гадаадын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай 18 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 7.3 хувийг, тэдгээрийн нийт актив ББСБ-ын нийт активын 15.7 хувийг, олгосон зээл нь нийт ББСБ-уудын олгосон зээлийн 15.7 хувийг, эзэмшигчдийн өмч нь нийт ББСБ -уудын эзэмшигчдийн өмчийн 14.6 хувийг, хувь нийлүүлсэн хөрөнгө нь нийт ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн 14.1 хувийг тус тус эзэлж байна.

№	Үндсэн үзүүлэлтүүд	2012 оны жилийн эцэст	2013 оны гуравдугаар улиралд	/Хүснэгт 10/ Өсөлт +/-, бууралт -/
	Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын тоо	17	18	+1
	ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь	8.49%	7.35%	-1.14%
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	44,357,733.6	49,852,656.0	5,494,922.40
	ББСБ-ын нийт активт эзлэх хувь	17.60%	14.49%	-3.11%
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	29,287,989.7	32,931,577.6	3,643,587.90
	Үүнээс: Чанаргүй зээл /мянган төгрөгөөр/	2,077,091.0	2,090,872.0	13,781.00
	ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	18.56%	15.71%	-2.85%
В	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	29,658,596.3	31,555,785.2	1,897,188.90
	ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь	17.31%	14.58%	2.73%
Г	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	23,698,562.5	24,300,362.5	601,800.00
	ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь	17.19%	14.13%	-3.06%
Д	Банк, банк бус санхүүгийн байгууллагаас татсан зээл /мянган төгрөгөөр/	9,981,488.9	12,575,330.1	2,593,841.20
	Үүнээс: Богино хугацаат зээл /мянган төгрөгөөр/	6,260,651.1	8,380,682.3	2,120,031.20
	Урт хугацаат зээл /мянган төгрөгөөр/	3,720,837.8	4,194,647.9	473,810.10
Е	Төслийн зээлийн санхүүжилт /мянган төгрөгөөр/	248,890.6	503,000.0	254,109.40
Ё	Нийт орлого /мянган төгрөгөөр/	11,078,371.0	10,856,016.7	-222,354.30
Ж	Нийт зардал /мянган төгрөгөөр/	9,233,042.6	8,547,053.9	-685,988.70
З	Тайлант үеийн ашиг /мянган төгрөгөөр/	1,845,328.4	2,278,587.3	433,258.90

Гадаадын хөрөнгө оруулагчдыг харьяаллаар нь авч үзвэл Дэлхийн Зөн Олон улсын байгууллагаас санхүүжигдсэн 1, Япон улсын хөрөнгө оруулалттай 10, БНСУ-ын хөрөнгө оруулалттай 4, Итали, ОХУ, БНХАУ-ын хөрөнгө оруулалттай тус бүр 1 ББСБ үйл ажиллагаа явуулж байна.

2013 оны гуравдугаар улирлын байдлаар гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид шинээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгогдоогүй бөгөөд энэ нь Улсын Их Хурлын 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр “Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай” хууль батлагдсанаар гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн

нэгжид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход Улсын Их Хурал, Засгийн газраас хэлцэл хийх зөвшөөрөл олгосны эцэст шийдвэрлэхээр заасантай холбоотой юм.

2013 оны эхний 9 сарын байдлаар Хороонд тусгай зөвшөөрөл хүссэн гадаадын хөрөнгө оруулалттай нэр бүхий 5 аж ахуйн нэгжийн хүсэлт ирснээс Засгийн газрын 2013 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 193, 7 дугаар сарын 09-ний өдрийн 264 дүгээр тогтоолуудаар нийт 4 компанид хэлцэл хийх зөвшөөрөл олгогдсон бөгөөд тайлант хугацааны байдлаар нэр бүхий 2 компаниас ирүүлсэн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлттэй холбогдох баримт бичгүүдийг Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам” -ын дагуу хянаж байна.

2.4 Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэн явуулж буй ББСБ:

Тайлант хугацаанд буюу 2013 оны гуравдугаар улирлын байдлаар нийт 35 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгосноос 11.4 хувь буюу 4 ББСБ-д банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байна.

Хорооноос тусгай зөвшөөрөл авсан нийт 245 ББСБ байгаагийн 99 ББСБ буюу 40.4 хувь нь гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгаагийн дотор 39 ББСБ нь зөвхөн гадаад валютын арилжааны үйл ажиллагааг дагнан эрхлэх зөвшөөрөлтэй байна.

Гадаад валютын арилжаа дангаар эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 39 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 15.9 хувийг, тэдгээрийн актив нийт ББСБ-ын активын 2.3 хувийг, эзэмшигчдийн өмч нь нийт ББСБ -ын эзэмшигчдийн өмчийн 3.6 хувийг, хувь нийлүүлсэн хөрөнгө нь нийт ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн 3.8 хувийг тус тус эзэлж байна.

/Хүснэгт 11/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2012 оны жилийн эцэст	2013 оны гуравдугаар улиралд	Өсөлт +/-, бууралт -/-
	Валютын арилжааны үндсэн үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	38	39	1
	ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь	17.92%	15.92%	-2.0%
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	8,105,754.72	8,002,989.0	102,765.72
	ББСБ-ын нийт активт эзлэх хувь	3.21%	2.33%	-0.88%
Б	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	7,547,276.99	7,838,876.4	291,599.41
	ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь	4.40%	3.62%	-0.78%
В	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	6,281,692.37	6,479,692.4	198,000.0
	ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь	4.51%	3.77%	-0.74%
Г	Төслийн зээлийн санхүүжилт /мянган төгрөгөөр/	9,981,488.90	-	-
Д	Нийт орлого /мянган төгрөгөөр/	8,688,029.3	1,051,332.50	-7,636,696.8
Е	Нийт зардал /мянган төгрөгөөр/	8,136,914.4	801,460.06	-7,335,454.3
Ё	Тайлант үеийн ашиг /мянган төгрөгөөр/	551,114.9	249,872.4	-301,242.5

ГУРАВ. АКТИВЫН БҮТЭЦ, ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 Активын бүтэц, өөрчлөлт:

Тайлант хугацаанд нийт ББСБ-уудын активын бүтэц эц өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд: /мянган төгрөгөөр/

/Хүснэгт 12/

№	ХӨРӨНГӨ	2012.9.30		2013.9.30		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
А	Эргэлтийн хөрөнгө	236,516,334.5	96.4%	333,150,202.80	96.83%	96,633,868.3	40.9%
1	Мөнгөн хөрөнгө	70,909,105.1	28.9%	95,234,327.59	27.68%	24,325,222.5	34.3%


2	Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	2,196,615.7	0.9%	9,839,961.66	2.86%	7,643,346.0	4.5дахин
3	Нийт зээл	154,406,025.7	62.9%	209,591,331.55	60.92%	55,185,305.9	35.7%
	(Зээлийн эрсдлийн сан)	4,415,536.6	1.8%	6,100,364.82	1.77%	1,684,828.2	38.2%
4	Нийт санхүүгийн түрээсийн тооцооны авлага	613,089.9	0.2%	81.35	0.00%	-613,008.6	-100.0%
	(Санхүүгийн түрээсийн эрсдлийн сан)	-	-	-	-	-	-
5	Нийт факторингийн тооцооны авлага	939,120.0	0.4%	808,620.00	0.24%	-130,500.0	-13.9%
	(Факторингийн авлагын эрсдлийн сан)	-	-	1,500.00	0.00%	-	-
6	Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	870,316.2	0.4%	833,310.56	0.24%	-37,005.6	-4.3%
7	Бусад хөрөнгө	10,997,598.5	4.5%	22,944,434.92	6.67%	11,946,836.4	2.1дахин
8	Санхүүгийн үүсмэл хэрэгсэл /дериватив/-ийн авлага	-	-	-	-	-	-
Б	Эргэлтийн бус хөрөнгө	8,869,964.4	3.6%	10,913,820.00	3.17%	2,043,855.6	23.0%
9	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө /цэврээр/	8,869,964.4	3.6%	10,913,820.00	3.17%	2,043,855.6	23.0%
	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	11,483,013.0	4.7%	14,435,809.06	4.20%	2,952,796.1	25.7%
	(Хуримтлагдсан элэгдэл)	2,613,048.7	1.1%	3,521,989.06	1.02%	908,940.4	34.8%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		245,386,298.8	100.0%	344,064,023.00	100.00%	98,677,724.2	40.2%

2013 оны гуравдугаар улирлын байдлаар банк бус санхүүгийн тусгай зөвшөөрөлтэй 245 компани нь 344,064,023.0 мянган төгрөгийн актив хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа явуулж байгаа ба активын өсөлт нь 2012 оны жилийн эцсийн байдлаас 92,010,481.6 мянган төгрөгөөр буюу 36.5 хувиар, өмнөх оны тайлант үетэй харьцуулахад 98,677,724.2 мянган төгрөгөөр буюу 40.2 хувиар тус тус өссөн байна.

Тайлант хугацаанд нийт активын 96.8 хувь нь эргэлтийн хөрөнгө, 3.2 хувь нь эргэлтийн бус хөрөнгө байна.

ББСБ-уудын нийт активын голлох үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна.

/График 3/



3.2 Зээлийн багцын чанар:

Зээлийн ангиллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.


/Хүснэгт 13/

№	Ангилал	2012.9.30		2013.9.30		Өөрчлөлт	
		Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь
1	Хэвийн	144,250,247.2	93.4%	193,169,905.9	92.2%	48,919,658.7	33.9%
2	Хугацаа хэтэрсэн	4,163,519.7	2.7%	6,795,808.1	3.2%	2,632,288.4	63.2%
3	Чанаргүй зээл. Үүнээс	5,992,258.7	3.9%	9,625,617.5	4.6%	3,633,358.8	60.6%
	Хэвийн бус	1,537,629.9	1.0%	3,749,532.2	1.8%	2,211,902.3	1.4 дахин
	Эргэлзээтэй	1,308,157.9	0.8%	2,153,287.7	1.0%	845,129.8	64.6%
	Муу	3,146,470.9	2.0%	3,722,797.6	1.8%	576,326.7	18.3%
	(Зээлийн эрсдлийн сан)	4,415,536.6	2.9%	6,100,364.8	2.9%	1,684,828.2	38.2%
	Нийт зээл	154,406,025.7	100.0%	209,591,331.5	100.0%	55,185,305.8	35.7%

2013 оны гуравдугаар улирлын байдлаар зээлийн үүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад, нийт зээлийн багц 35.7 хувиар өссөнөөс зээлийн багцад эзлэх хувийн жингээр хэвийн зээл 33.9 хувиар, хугацаа хэтэрсэн зээл 63.2 хувиар, чанаргүй зээл 60.6 хувиар тус тус өсч зээлийн чанарт ахиц гараагүй байна гэж үзэж байна.

ББСБ-уудын нийт зээлийн багцын бүтцийг өмнөх онуудтай харьцуулбал:

/График 4/



3.3 Зээлийн хүү:

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй нийт 245 ББСБ-аас 82.8 хувь буюу 203 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна. ББСБ-уудын зээлийн сарын хамгийн дээд хүү 8.0 хувь, хамгийн бага хүү 0.5 хувь байна.

ББСБ-уудын зээлийн сарын дундаж дээд хүү 3.8 хувь, зээлийн дундаж доод хүү 2.3 хувь буюу нийт ББСБ-ын зээлийн сарын дундаж хүү 3.1 хувь байна.

ББСБ-ын зээлийн хүүг банкны зээлийн хүүтэй харьцуулбал дараах байдалтай байна.

/График 5/



Активын бусад үзүүлэлтийн талаар:

Санхүүгийн түрээсийн тооцооны авлага 81.3 мянган төгрөг, факторингийн тооцооны авлага 808,620.0 мянган төгрөг бүртгэгдсэн байна.

2013 оны 01 дүгээр улирлаас эхлэн ББСБ -аас ирүүлж буй зохистой харьцааны тайланд шинээр нэмж тухайн улиралд олгосон зээл, эргэнөпөлтийн талаарх судалгаа, мөн оны 02 дугаар улирлын тайланд гадаадын даатгалын байгууллагад даатгагдсан эсэх талаарх судалгаануудыг авч эхэлсэн.

Дээрх олгосон зээл, эргэн төлөлтийн талаарх судалгаанд зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг нийт 203 ББСБ-аас 151 ББСБ нь буюу 74.4 хувь нь хамрагдсан бөөдө судалгаанд хамрагдсан ББСБ-уудад тайлант хугацаанд 183,238.4 сая төгрөгийн зээл олгож, 145,171.6 сая төг рөгийн зээл эргэн төлөгдсөн байна.

Харин тайлант хугацаанд тайлан ирүүлбэл зохих нийт 245 ББСБ-аас 243 ББСБ тайлангаа ирүүлсний дотор гадаадын даатгалын байгууллагад даатгагдсан ББСБ байхгүй байна.

ДӨРӨВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ӨӨРЧЛӨЛТ

ББСБ-уудын 2013 оны гуравдугаар улирлын байдлаарх нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзэхэд дараах байдалтай байна.

/мянган төгрөгөөр/

/Хүснэгт 14/

№	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	2012.9.30		2013.9.30		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
A	Өр төлбөр	73,040,854.2	29.8%	109,567,858.8	31.8%	36,527,004.6	50.0%
1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	15,726,070.9	6.4%	18,366,924.1	5.3%	2,640,853.2	16.8%
2	Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	48,891,638.1	19.9%	76,367,818.8	22.2%	27,476,180.7	56.2%
3	Бусад эх үүсвэр	3,002,943.3	1.2%	2,511,755.1	0.7%	-491,188.2	-16.4%
	Зээлийн батлан даалтанд байршуулсан эх үүсвэр	600.0	0.0%	3,949.6	0.0%	3,349.6	5.6 дахин
	Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	2,968,531.5	1.2%	2,507,727.2	0.7%	-460,804.3	-15.5%
	Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг	33,811.8	0.0%	78.2	0.0%	-33,733.6	-99.8%
	Факторингийн үйлчилгээний өглөг	-	-	-	-	-	-

	Гадаад валютын арилжааны эх үүсвэр	-	-	-	-	-	-
4	ББСБ-аас гаргасан өрийн бичиг	-	-	1,192,800.0	0.3%	1,192,800.0	-
5	Төслийн зээлийн санхүүжилт	5,420,201.9	2.2%	11,128,560.7	3.2%	5,708,358.9	1.0дахин
Б	Бусад өр төлбөр	10,105,323.3	4.1%	18,124,467.4	5.3%	8,019,144.1	79.4%
6	Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	2,460,434.0	1.0%	2,518,427.1	0.7%	57,993.1	2.4%
7	Бусад пассив	7,644,889.3	3.1%	15,606,040.3	4.5%	7,961,151.0	1.0дахин
8	Санхүүгийн үүсмэл хэрэгсэл /дериватив/-ийн өглөг	-	-	-	-	-	-
Нийт өр төлбөр		83,146,177.5	33.9%	127,692,326.2	37.1%	44,546,148.7	53.6%
Б	Эзэмшигчдийн өмч	162,240,121.3	66.1%	216,371,696.6	62.9%	54,131,575.3	33.4%
9	Хувьцаат капитал	133,289,227.1	54.3%	172,025,247.3	50.0%	38,736,020.2	29.1%
10	Бусад өмч	4,002,716.0	1.6%	7,749,272.0	2.2%	3,746,556.0	93.6%
11	Сангууд	1,180,841.6	0.5%	186,341.9	0.1%	-994,499.7	-84.2%
12	Хуримтлагдсан ашиг/алдагдал	21,199,030.2	8.6%	33,980,365.8	9.9%	12,781,335.6	60.3%
13	Хоёрдогч өглөг /5 жилээс дээш хугацаатай/	2,568,306.4	1.0%	2,430,469.5	0.7%	-137,836.9	-5.4%
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		245,386,298.8	100.0%	344,064,023.0	100.0%	98,677,724.2	40.2%

2012 оны жилийн эцсийн тайлангаар нийт эхүүсвэрийн 32.0 хувийг нийт өр төлбөр, 68.0 хувийг эзэмшигчийн өмч эзэлж байсан бол 2013 оны гуравдугаар улирлын байдлаар нийт өр төлбөр 37.1 хувь, эзэмшигчийн өмч 62.9 хувь болж өөрчлөгдсөн байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт өр төлбөр 53.6 хувиар, эзэмшигчдийн өмч 33.4 хувиар тус тус өссөн байна.


2013 оны гуравдугаар улиралд нийт эхүүсвэрт эзлэх өр төлбөр өссөн гол шалтгаан нь ББСБ-уудын дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл 76,367.8 сая төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 56.2 хувиар буюу 27,476.2 сая төгрөгөөр, итгэлцлийн үйлчилгээний өглөг 18,366.9 сая төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 16.8 хувиар буюу 2,640.8 сая төгрөгөөр, бусад пассив 15,606.0 сая төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1.0 дахин буюу 7,961.1 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой.

Өөрийн хөрөнгийн эх үүсвэр нэмэгдсэн нь ББСБ-уудын өөрийн хөрөнгөөр эрсдэл даах чадварыг нэмэгдүүлж, улмаар санхүүгийн тогтвортой байдлын хувьд эерэг үзүүлэлт болж байна.

Мөн банк бус санхүүгийн байгууллага шинээр нэмэгдэж иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх сонирхол нэмэгдсэнтэйгээ р хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өсч байна.

ББСБ-уудын системийн нийт пассивын гүйцэтгэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна.

/График 6/



2013 оны гуравдугаар улирлын байдлаар итгэлцлийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй 20 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 7.7 хувийг, тэдгээрийн нийт актив нийт ББСБ-ын активын 37.2 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчдийн өмчийн 32.9 хувийг тус тус эзэлж байна.

Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 5 ББСБ байгаагаас 2013 оны гуравдугаар улирлын тайлант хугацаанд 2,507,727.3 мянган өгрөгийн цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын өглөг бүртгэгдсэн.

2013 оны гуравдугаар улирлын байдлаар хоёрдогч өглөгтэй 8 ББСБ-д 2,430,469.5 мянган төгрөгийн хоёрдогч өглөг бүртгэгдсэн байна.

Хорооны 2010 оны 199 дүгээр тогтоолоор “Банк бус санхүүгийн байгууллагаас хаалттай өрийн бичиг гаргах журам”-ыг батлан мөрдөж эхэлсэн ба энэхүү журмыг 2012 оны 248 дугаар тогтоолоор хүчингүй болгож “Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичиг бүртгэх журам”-ыг шинэчлэн баталж, өмнө оны 346 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан.

Хаалттай өрийн бичгийн зөвшөөрөлтэй нэр бүхий 3 ББСБ нь нийт 3,000.0 сая төгрөгийн өрийн бичиг гаргахаар Хороонд бүртгүүлсэн бөгөөд 2013 оны гуравдугаар улирлын байдлаар нийт 1,192.8 сая төгрөгийн хаалттай өрийн бичгийг гаргаад байна.

ТАВ. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГАА

2013 оны гуравдугаар улирлын байдлаар 245 ББСБ нь нийт 21,045,129.0 мянган төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1.5 дахин буюу 7,591,862.6 мянган өгрөгөөр, нийт орлого 26,002,092.3 мянган төгрөгөөр, зардал 18,410,229.7 мянган төгрөгөөр тус тус өссөн байна. Үүнд: /мянган төгрөгөөр/

/Хүснэгт 19/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2012.09.30	2013.09.30	Өөрчлөлт
		Дүн	Дүн	Дүн
1	НИЙТ ОРЛОГО	46,049,831.7	72,051,924.0	26,002,092.30
2	НИЙТ ЗАРДАЛ	32,596,565.3	51,006,795.0	18,410,229.70
3	ТАТВАРЫН ДАРААХ ЦЭВЭР АШИГ	13,453,266.4	21,045,129.0	7,591,862.60

Нийт орлого өмнөх оны мөн үеэс 156.5 хувиар буюу 1,6 дахин өссөн ба дараах үндсэн бүтэцтэй байна. Үүнд: /мянган төгрөгөөр/

/Хүснэгт 20/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2012.9.30		2013.9.30		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь

1	ХҮҮГИЙН ОРЛОГО	31,634,081.4	68.7%	46,203,470.30	64.1%	14,569,388.90	46.1%
	Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	29,953,746.5	65.0%	44,738,304.60	62.1%	14,784,558.10	49.4%
	Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого	747,659.0	1.6%	830,022.60	1.1%	82,363.60	11.0%
	Бусад хүүгийн орлого	932,675.9	2.0%	635,143.10	0.9%	-297,532.80	-31.9%
2	ХҮҮГИЙН БУС ОРЛОГО	13,298,346.0	28.9%	24,868,545.30	34.5%	11,570,199.30	87.0%
3	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	1,010,573.0	2.2%	878,128.10	1.2%	-132,444.90	-13.1%
4	ЕРДИЙН БУС ОРЛОГО	106,831.3	0.2%	101,780.30	0.1%	-5,051.00	-4.7%
	НИЙТ ОРЛОГО	46,049,831.7	100.0%	72,051,924.00	100.0%	26,002,092.30	56.5%

Тайлант хугацааны нийт орлогын 64.1 хувийг хүүгийн орлого /өмнөх оны мөн үетэй харьцуулахад 46.1 хувиар өссөн/ , 34.5 хувийг үгүйн бус орлого /өмнөх оны мөн үетэй харьцуулахад 87.0 хувиар өссөн/ эзэлж байна.

Хүүгийн орлогын 62.1 хувийг хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого, 1.1 хувийг хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого эзэлж байна.

Хүүгийн бус орлого нь дараах үндсэн бүтэцтэй байна. Үүнд: /мянгавгрөгөөр/
/Хүснэгт 21/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2012.9.30		2013.9.30		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	Арилжааны орлого	4,499,768.4	33.8%	3,772,613.4	15.2%	-727,155.0	-16.2%
1.1	Гадаад валютын арилжааны орлого	3,620,687.2	27.2%	3,772,268.0	15.2%	151,580.8	4.2%
1.2	Үнэт цаасны арилжааны орлого	879,081.2	6.6%	345.4	0.0%	-878,735.8	-100.0%
2	Ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого	5,747,518.3	43.2%	16,932,532.3	68.1%	11,185,014.0	2.9 дахин
2.1	Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	4,954,803.9	37.2%	15,980,800.0	64.3%	11,025,996.1	3.2 дахин
2.2	Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн орлого	792,714.4	6.0%	951,732.2	3.8%	159,017.8	20.1%
3	Санхүүгийн үйлчилгээний орлого	3,051,059.3	22.9%	4,163,399.6	16.7%	1,112,340.3	36.5%
3.1	Санхүүгийн түрээсийн орлого	-	-	842.0	0.0%	842.0	
3.2	Итгэлцлийн үйлчилгээний орлого	-	-	-	-	-	-
3.3	Мөнгөн гуйвуулгын орлого	648,734.4	4.9%	535,889.4	2.2%	-112,845.0	-17.4%
3.4	Каргын үйлчилгээний орлого	-	-	-	-	-	-
3.5	Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	76,303.7	0.6%	397,276.1	1.6%	320,972.4	4.2 дахин
3.6	Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	1,559,166.1	11.7%	2,804,804.0	11.3%	1,245,637.9	1.8 дахин
3.7	Бусад	766,855.1	5.8%	424,588.1	1.7%	-342,267.0	-44.6%
	ХҮҮГИЙН БУС ОРЛОГО НИЙТ	13,298,346.0	100.0%	24,868,545.3	100.0%	11,570,199.3	1.9 дахин

2012 оны гуравдугаар улирлын байдлаар нийтүгүйн бус орлогын 33.8 хувийг гадаад валютын арилжааны орлого, 43.2 хувийг ханшийн тэгшитгэлийн орлого, 22.9 хувийг бусад санхүүгийн үйлчилгээний орлого эзэлж байсан бол 2013 оны гуравдугаар улирлын байдлаар нийт үгүйн бус орлогын 15.2 хувийг гадаад валютын арилжааны орлого, 68.1 хувийг

ханшийн тэгшитгэлийн орлого, 16.7 хувийг бусад санхүүгийн үйлчилгээний орлого тус тус эзэлж байна.

Нийт зардлын бүтэц дараах байдалтай байна. Үүнд: /мянган төгрөгөөр/


/Хүснэгт 22/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2012.9.30		2013.9.30		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	ХҮҮГИЙН ЗАРДАЛ	4,772,361.8	14.6%	6,169,345.7	12.1%	1,396,983.9	29.3%
2	ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ	23,610,022.6	72.4%	38,569,482.1	75.6%	14,959,459.5	63.4%
3	БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН ЗАРДАЛ	1,833,439.1	5.6%	2,808,608.3	5.5%	975,169.2	53.2%
4	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	671,952.1	2.1%	874,392.7	1.7%	202,440.6	30.1%
5	ЕРДИЙН БУС ЗАРДАЛ	16,843.0	0.1%	15,360.1	0.0%	-1,482.9	-8.8%
6	ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ	1,691,946.7	5.2%	2,569,606.1	5.0%	877,659.4	51.9%
	НИЙТ ЗАРДАЛ	32,596,565.3	100.0%	51,006,795.0	100.0%	18,410,229.7	56.5%

2013 оны гуравдугаар улирлын байдлаар нийт зардал өмнөх оны мөн үеэс 56.5 хувиар өссөн байх ба ердийн бус зардал 8.8 хувиар буурч бусад зардлууд 29.3-63.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

ББСБ-уудын нийт орлого, зардлын үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна.

/График 7/



Тайлант хугацаанд 199 ББСБ буюу нийт ББСБ-ын 81.2 хувь нь ашигтай ажиллаж тэдгээрийн нийт ашиг 22,911,728.6 мянган төгрөгт хүрсэн байна.

ЗУРГАА. БҮЛГИЙН САНХҮҮГИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Нийт ББСБ-уудыг активын хэмжээгээр нь 400,000.0 мянган өгрөг хүртэл активтай 400,000.0 мянган өгрөгөөс 1,000,000.0 мянган төгрөг хүртэл активтай, 1,000,000.0 мянган төгрөг ба түүнээс дээш төгрөгийн активтай ББСБ гэсэн 3 бүлэгт хуваан тооцов.

2013 оны гуравдугаар улирлын байдлаарх бүлгүүдийн бүтэц дараах байдалтай байна:

/Хүснэгт 23/

№	Бүлэг	Бүлэгт хамаарах ББСБ-ын	Бүлгийн нийт актив		Нэмэлт мэдээлэл
			Актив /мянган төгрөг/	Нийт активт эзлэх хэмжээ/хувь/	

		тоо			
1	Бүлэг 01	58	268,900,111.9	78.2%	1,000,000.0 мянган төгрөгөөс дээш хэмжээний активтай
2	Бүлэг 02	115	63,331,279.4	18.4%	400,000.0 мянган төгрөгөөс 1,000,000.0 мянган төгрөг хүртэл хэмжээний активтай
3	Бүлэг 03	72	11,832,631.4	3.4%	400,000.0 мянган төгрөг хүртэл хэмжээний активтай
НИЙТ		245	344,064,023.0	100.0%	100.00%

Бүлгүүдийн санхүүгийн голлох үзүүлэлтүүдийг харьцуулахад “Бүлэг 01”-д хамаарах 58 ББСБ нь нийт ББСБ-ын 23.7 хувийг, нийт активын 78.2 хувийг эзэлж байна.

ДОЛОО. САЛБАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Тайлант хугацаанд Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг 1 94 ББСБ бүрэн хангаж ажилласан, 51 ББСБ 1-4 үзүүлэлтийг хангаж ажиллаагүй үзүүлэлттэй байгаагаас 1 харьцааг хангаж ажиллаагүй 28 ББСБ, 2 харьцааг хангаж ажиллаагүй 19 ББСБ, 3 харьцааг хангаж ажиллаагүй 3 ББСБ, 4 харьцааг хангаж ажиллаагүй 1 ББСБ байна.

Санхүүгийн тайлангийн нэгтгэлээр Хорооны 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон үзүүлэлтүүд системийн түвшинд дараах байдалтай байна. Үүнд:

- нийт өөрийн хөрөнгө 216,408,279.8 мянган төгрөг, эрсдэлээр жигнэсэн актив 258,337,474.6 мянган төгрөг байгаагаас өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлт нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын хувьд 82.6 хувь, өөрийн хөрөнгийн хувьд 89.4 хувь, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын хувьд 62.0 хувь;

- түргэн борлогдох актив 80,032,653.2 мянган өгрөг, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө 89,775,484.5 мянган төгрөг байгаагаас төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 89.1 хувь;

- валютын дансны цэвэр өрүү 16,084,336.0 мянган төгрөг, тухайн валютаарх өөрийн хөрөнгө 216,408,279.8 мянган төгрөг байгаагаас нийт гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа 7.43 хувь;

- итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийн үлдэгдэл 18,366,924.1 мянган төгрөг, өөрийн хөрөнгө 216,408,279.8 мянган төгрөг байгаагаас итгэлцлийн үйлчилгээний өглөг, өөрийн хөрөнгийн харьцаа 8.49 хувь;

- нийт цэвэрүүлсэн үндсэн хөрөнгө 4,318,987.3 мянган өгрөг, нийт актив 344,065,022.8 мянган төгрөг байгаагаас үндсэн хөрөнгө, нийт активын харьцаа 1.3 хувь байгаа нь зохистой харьцааны үзүүлэлтүүдийг тус тус хангасан байна.

Харин активын эрсдэлийн санг 6,238,495.8 мянган өгрөгөөр байгуулбал зохиоос 34,431.2 мянган төгрөгөөр илүү буюу нийт 6,272,927.1 мянган төгрөгөөр байгуулсан байна.²

НАЙМ. ДҮГНЭЛТ

1. Тайлант хугацаанд санхүүгийн тайлангийн нэгтгэлд тайлан ирүүлбэл зохих нийт 245 ББСБ-аас 243 ББСБ /99.2 хувь/ тайлангаа ирүүлсэн ба 3 ББСБ /1.2 хувь/ өмнөх үеүдийн санхүүгийн тайлангийн дүнгээр, 7 ББСБ /2.8 хувь/ эхлэлтийн тайлангаар тус тус нэгтгэлд хамрагдсан.

²Энэхүү тоон үзүүлэлтийг гаргахдаа тухайн ББСБ-уудын ТОП20 зээлдэгчийн мэдээлэлд тулгуурлан гаргасан болно.

2. Нийт 245 ББСБ-аас 14.3 хувь нь буюу 35 ББСБ нь банк бус санхүүгийн үйл ажиллагааны төрлүүдээс 3-4 төрлийн үйл ажиллагааг зэрэг эрхлэхээр тусгай өвшөөрөл эзэмшиж байгаа бөгөөд ББСБ -уудын хувьцаа эзэмшигчдийн өрөнгө санхүүгийн чадвараас хамаарч үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх хандлага сул байна.
3. ББСБ-уудын голлох үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт актив 92,010,481.6 мянган төгрөг буюу 36.5 хувь, нийт зээлийн өрийн үлдэгдэл 51,821,985.7 мянган төгрөг буюу 32.8 хувь, эзэмшигчдийн өмч 45,075,037.0 мянган төгрөг буюу 26.3 хувь, нийт хувь нийлүүлсэн хөрөнгө 32,831,021.1 мянган төгрөг буюу 23.6 хувиар тус тус өссөн байна.
4. ББСБ-уудын нийт актив 2013 оны гуравдугаар улирлын байдлаар 344,064,023.0 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт активын /банкны салбарын нийт актив 18,155,548,703.9 мянган төгрөг/ 1.9 хувь, нийт зээлийн өрийн үлдэгдэл 209,591,331.5 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт зээлийн /банкны салбарын нийт зээл 10,227,720,607.5 мянган төгрөг/ 2.0 хувь, чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 9,625,617.5 мянган төгрөг байгаа нь банкны салбарын чанаргүй зээлийн /банкны салбарын чанаргүй зээл 535,569,843.4 мянган төгрөг/ 1.8 хувь, нийт хувь нийлүүлсэн хөрөнгө 172,025,247.3 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн /банкны салбарын нийт хувь нийлүүлсэн хөрөнгө 366,908,947.4 мянган төгрөг/ 46.9 хувьтай тус тус тэнцэж байна.
5. Тайлант хугацаанд 1 дүгээр бүлгийн буюу 1,0 тэрбум төгрөгөөс дээш актив хөрөнгөтэй 58 ББСБ байгаа ба тэдгээрийн нийт актив 268.9 тэрбум төгрөг байгаа нь нийт ББСБ -уудын активын 78.2 хувийг эзэлж байна.
6. 2013 онд Хороонд өвлөрүүлбэл зохих нийт 212 Б БСБ-ын 208,055.0 мянган өгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлс төлөгдөхөөс 2013 оны гуравдугаар улирлын байдлаар нийт 204 ББСБ-ын 203,850.0 мянган өгрөгийн зохицуулалт үйлчилгээний хөлсийг Хорооны дансанд төвлөрүүлсэн нь 98.0 хувьтай байна.
7. Зээлийн мэдээллийн тухай хууль 2011 оны 10 дугаар 20-ны өдөр батлагдан гарснаар санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор зээлийн үйл ажиллагаа эрхлэхийг хуулиар өвшөөрсөн байгууллага зээлийн мэдээллийн сантай байхаар хуульчилсны дагуу тайлант хугацаанд нийт 83 ББСБ Монголбанкны зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээ байгуулан, зээлдэгчийн талаарх мэдээлэл, лавлагааг зээлийн үйл ажиллагаандаа авч ашиглаж байгаа нь зээлийн үйл ажиллагаа эрхлэх 203 ББСБ-ын 40.9 хувийг, нийт 245 ББСБ-ын 33.9 хувийг тус тус эзэлж байна.
8. “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн хэрэгжилтийг газар дээр нь шалгах ажлын үрээнд 2011 оны IV улирлаас эхлэн газар дээрх хяналт шалгалтын удирдамжид “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн хэрэгжилтийн талаар хэсэг оруулж, 2013 оны гуравдугаар улирлын байдлаар 23 ББСБ-ын банк бус санхүүгийн тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд төлөвлөгөөт бүрэн хэмжээний газар дээрх шалгалт, ЦЕГ, УМБГ-ын хүсэлтээр 1 ББСБ-д хэсэгчилсэн шалгалт, нэр үсхий 41 аж ахуйн нэгж, иргэдийг хамруулан гэнэтийн үзлэг хийгдсэн бөгөөд дээрх үзлэг, шалгалтыг хийх явц даа “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн 5.2 -д заасны дагуу эцэг /эх/-ийн нэр, оршин суугаа хаяг, регистрийн дугаар, холбоо барих утасны дугаар, цээж зураг зэрэг шаардлагатай мэдээллийг авч байгаа эсэхэд хяналт тавин ажилласан ба нийт 88 ББСБ нь Хорооны 2009 оны 253 дугаар тогтоолоор батлагдсан “Харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэнлөний гүйлгээ мэдэ элэх журам”-ын дагуу хуулийн хэрэгжилтийг хариуцсан байнгын хяналт тавих ажилтныг томилон, шийдвэрийг Хороонд ирүүлсэн байна.
9. Нийт 212 ББСБ нь Аудитын тухай хуулийн 7 дугаард заасны дагуу 2012 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хөндлөнгийн аудитаар баталгаажуулах хуулийн

хариуцлагатайгаас 98.1 хувь буюу 208 ББСБ-ийн санхуйлангаа аудитаар баталгаажуулан Хороонд ирүүлсэн байна.

10. Бичил санхүүгийн хөгжлийн сангаас дамжуулан зээлдүүлэх сонгон шалгаруулалтад 23 ББСБ-ын санхүүгийн үзүүлэлтүүдийн талаарх судалгаа хийгдсэн бөгөөд 2013 оны гуравдугаар улирлын байдлаар 11,128.6 өсрөгийн төслийн зээлийн өрийн үлдэгдэлтэй байна.

ЁС. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

1. Зээлийн мэдээллийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монголбанкны ЗМС-д холбогдсон ББСБ-уудын тоог нэмэгдүүлнэ.
2. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулна.
3. Хөдөө орон нутаг дахь ББСБ-уудын үйл ажиллагаанд гүйцэтгэх газар дээрх хяналт, шалгалтын ажлыг идэвхижүүлнэ.
4. Орон нутгийн төлөөлөгч нартай нягт хамтран ажиллана.
5. Үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах, санхүү, төлбөрийн чадварыг тогтворжуулах, хууль, журмын хэрэгжилтийг хангуулах зорилгоор ББСБ-уудын удирдлага, ажилтнуудад зориулсан сургалт, өвөлгөөг нийслэл болон орон нутагт бүсчлэн зохион байгуулах, сургалтын үр өгөөжийг дээшлүүлэхэд анхаарч ажиллана.

БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР